

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨРӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ
НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ,
ҮР ДҮН

АУДИТЫН КОД: АГГ-2022/20-ШТА-ГА

ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

Даланзадгад хот 2022 он



Дарга, Тэргүүлэх аудитор С.Цэрэнбаяр

Утас: 70533539 Цахим хаяг: Tserenbayars@audit.gov.mn

Аудитын менежер Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор Д.Сүрэнжаргал

Утас: 70533552 Цахим хаяг: Surenjargald@audit.gov.mn

Аудитор С.Одончимэг

Утас: 70533552 Цахим хаяг: Odonchimegs@audit.gov.mn

Аудитор Э.Жаргал

Утас: 70533552 Цахим хаяг: Jargale@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу: Цахим хаяг: www.audit.mn

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

Аудитыг гүйцэтгэсэн:	Агуулга	Хуудас
Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр	Товчилсон үгийн тайлбар	4
	Хүснэгт, график, зургийн жагсаалт	4-5
	Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	6-7
Аудитын менежер: Т.Хонгорзул	Бүлэг 1. Төрийн байгууллагуудын чиг үүрэг харилцан уялдаатай байна	
Ахлах аудитор: Д.Сүрэнжаргал	1.1 Төрөөс хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлтэй уялдаж байна	8-11
Аудитор: С.Одончимэг Э.Жаргал	1.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг тооцоо судалгаанд үндэслээгүй байна	
	1.3 Төрийн байгууллагуудын чиг үүрэг харилцан уялдаатай байгаа боловч хяналт, шинжилгээ үнэлгээ үр дүнгүй байна	
	Бүлэг 2. Хөтөлбөрийн санхүүжилтийг хэт бага дүнгээр хуваан олгож байгаа нь хөтөлбөрийн үр дүнг бууруулж байна	
2022 оны 04 дүгээр сар	2.1 Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажилд зуучлах арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан байна.	11-13
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70533539, 70533552 дугаарын утсаар харилцана уу.	2.2 Нэгдсэн бүртгэл, мэдээллийн системийг бүрэн ашиглаж байна	13-14
	2.3 Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд зарцуулсан хөрөнгийн үр ашгийг бодитой тооцож, тайлагнасан байна	14
	2.4 Дэлхийн банкны санхүүжилтээр “Бичил бизнесийг дэмжих” хөтөлбөрийг хэрэгжүүлж ажилласан байна.	14
Тайланг ӨМТАГ-ын www.umnu.govi@audit.gov.mn цахим хуудаснаас үзнэ үү.	2.5 Хөтөлбөрүүдийн хэрэгжилт, зээлийн эргэн төлөлтөд тавих хяналт хангалтгүй байгаа нь хөтөлбөрийн үр дүнг бууруулж байна	15-19
	2.6 Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар зохион байгуулсан арга хэмжээ байхгүй байна	19
	2.7 Орон нутгийн төсвөөс хуваарилах хөрөнгийг дэд санд төвлөрүүлээгүй байна	20-22
Хаяг: Нутгийн удирдлагын ордон, 3 давхар, 303 тоот	2.8 Сангийн хөрөнгийг хууль журмын дагуу орон нутгийн онцлогт тохируулан зарцуулсан ч хөтөлбөрүүдийн үр дүнг тооцоогүй байна	22-23
	2.9 Мэргэжлийн боловсрол олгох сургалтын байгууллагаас хөдөлмөрт бэлтгэх үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлсэн байна	24-26
	2.10 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн хөнгөлөлт, чөлөөлөлт нь аж ахуй нэгж, иргэдэд дэмжлэг болсон байна	27—29

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

Дүгнэлт	30
Зөвлөмж	31
Холбогдох байгууллагын санал	32
Тэргүүлэх аудиторын тушаал	33
Хавсралт №1	34
Хавсралт №2	35

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УИХ	Улсын Их хурал
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ХХҮЕГ	Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газар
ХХҮГ	Хөдөлмөр халамж үйлчилгээний газар
НБХ	Нийгмийн бодлогын хэлтэс
ПТК	Политехникийн коллеж
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХЭҮЗ	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл

Хүснэгт, Дүрслэл, графикийн жагсаалт

Дугаар	Тайлбар	Хуудас
Хүснэгт 1	Орон нутгаас хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр, хүрсэн үр дүн	8
Хүснэгт 2	ХХҮГ-н ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, ажилд зуучлах үйлчилгээ байдал	11
Хүснэгт 3	Ганцаарчилсан сургалтад хамрагдсан байдал	12
Хүснэгт 4	Бүлгийн сургалтад хамрагдсан байдал	12
Хүснэгт 5	Хөдөлмөрийн биржийн үйлчилгээ үзүүлсэн байдал	14
Хүснэгт 6	ХЭДС-ийн орлогыг эх үүсвэр	20
Хүснэгт 7	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөр төлсөн аж ахуй нэгж байгууллага	21
Хүснэгт 8	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулсан нийт хөрөнгө	22
Хүснэгт 9	ХЭДС-ийн хөрөнгийн төсвийн гүйцэтгэл	23
Хүснэгт 10	ХЭДС-аас төсөл хөтөлбөрүүдэд зарцуулсан хөрөнгө	24
Хүснэгт 11	Ажилгүйдлийн түвшин ба хөдөлмөр эрхлэлтийн судалгаа	24
Хүснэгт 12	Мэргэжлийн боловсрол олгосон байдал	26
Хүснэгт 13	Нийгмийн даатгалын хөнгөлөлт, чөлөөлөлтийн байдал	27
Хүснэгт 14	Сайн дурын даатгалын чөлөөлөлтөд хамрагдсан байдал	27

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

Хүснэгт 15	Аж ахуй эрхлэлтийг сэргээх хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээ	28
Хүснэгт 16	Цар тахлын үеийн хөдөлмөрийн зах зээлийн статистик	29
График 1	Хөдөлмөрийн зах зээлийн статистик мэдээ	9
График 2	Ажлын байранд бүртгэлтэй болон ажилд зуучлагдсан иргэд	13
График 3	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хэрэгжүүлэгчийг үйл ажиллагааны чиглэл	15
График 4	Малчдын хөдөлмөр эрхлэлтэд зарцуулсан хөрөнгө, хамрагдсан иргэн	16
График 5	Ахмад настны хөдөлмөр эрхлэлтэд зарцуулсан хөрөнгө, хамрагдсан иргэн	17
График 6	ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтэд зарцуулсан хөрөнгө, хамрагдсан иргэн	18
График 7	35-аас дээш насны хөдөлмөр эрхлэлтэд зарцуулсан хөрөнгө, хамрагдсан иргэн	19
График 8	Өмнөговь аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого	20
График 9	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийн орлого	21
График 10	Санхүүгийн дэмжлэгийн хугацаандаа эргэн төлөгдөөгүй хөрөнгө	22
График 11	Мэргэжлийн сургалтын байгууллагад олгосон санхүүгийн дэмжлэг	25
График 12	Өмнөговь аймгийн Политехникийн коллежийн төсвийн зардлын гүйцэтгэл	25
Зураг 1	Иргэн Х.Тэгш-амгаланд олгосон төсөл хөтөлбөрийн хэрэгжилт	15
Зураг 2	Гэрлийн дулаанаар хөрсгүй тариалалт	16
Дүрслэл 1	Хөтөлбөрт хамрагдсан ахмадын хөдөлмөр эрхлэлтийн байдал	17
Дүрслэл 2	Хөтөлбөрт хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал	18
Дүрслэл 3	Хөтөлбөрт хамрагдсан 35-аас дээш насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал	19

Аудитын зорилт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2021 оны 6 дугаар тогтоол, МҮЕА-ын 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн хийлээ.

Аудитын зорилт:

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүнг тооцож, дүгнэлт, зөвлөмжийг боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэв.

Зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын баримт бичиг, мөн төрийн байгууллагуудын бүтэц, чиг үүргийн уялдаа холбоо хангагдсан эсэх,
- Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн, хөрөнгийн зарцуулалт үр ашигтай байгаа эсэх.

Аудитын арга зүй:

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, 300, 3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит, Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-д заасан арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөрт дурдсан хугацаанд шалгах хуудсаар нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.

Хамрах хүрээ:

Аудитад Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 320 дугаар тогтоолоор баталсан Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогын баримт бичигт тусгасан төсөл, хөтөлбөр зорилго, зорилт, арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх, биелэлтийн явц, үр дүнг тооцон тайлагнах, үнэлж дүгнэх үүрэг хүлээсэн аймгийн Нийгмийн бодлогын хэлтэс, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, хөдөлмөрийн биржийн 2016-2021 оны үйл ажиллагааг хамрууллаа.

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

**Аудитад
ашигласан
шалгуур:**

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа.

Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хуулийн 25.1.7 дахь заалт; /1992 он/
- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 3-20 дугаар зүйл; /2015 он/
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 3-6, 8-21, 24 дүгээр зүйл; /2020 он/
- Төсвийн тухай хууль; /2011 он/
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 4-26 дугаар зүйл; /2011 он/
- Монгол Улсын нэгдсэн төсвийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн тухай хууль; /2017, 2018, 2019, 2020, 2021 он/
- Монгол Улсын 2017-2021 оны төсвийн тухай хууль;
- Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль;
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль; /2006 он/
- Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны “Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм
- Өмнөговь аймгийг 2016-2020 онд хөгжүүлэх аймгийн Засаг даргын үйл ажиллагааны “Бид хамтдаа” хөтөлбөр,
- Өмнөговь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны “Нутгийн хишиг” хөтөлбөр,
- Өмнөговь аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2016-2020 оны үндсэн чиглэл,
- Өмнөговь аймгийг 2021 онд хөгжүүлэх жилийн төлөвлөгөө

**Аудит хийсэн
багийн
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор С.Цэрэнбаяр удирдаж, аудитын менежер Т.Хонгорзул арга зүйгээр хангаж, ахлах аудитор Д.Сүрэнжаргал, аудитор С.Одончимэг, Э.Жаргал нар 2022 оны 3 дугаар сарын 3-ны өдрөөс 2022 оны 5 дугаар сарын 5-ны өдөр хүртэл хугацаанд гүйцэтгэлээ.

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

БҮЛЭГ 1 Төрийн байгууллагуудын чиг үүрэг харилцан уялдаатай байна

Төрөөс хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлтэй уялдаж байна

1.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх дунд, богино хугацааны бодлогыг Өмнөговь аймгийг 2016-2020 онд хөгжүүлэх “Бид хамтдаа”, 2020-2024 онд хөгжүүлэх “Нутгийн хишиг” хөтөлбөрүүдэд дараах байдлаар тусган хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт-1 Орон нутгаас хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр, хүрсэн үр

Он	Зорилт, арга хэмжээ	Нийт төсөв /сая төг/	Хэрэгжилт				
			Иргэдэд олгосон санхүүжилт /сая төгрөг		Сургалтаар		
			Орон нутгийн төсөв	Төсөл хөтөлбөр	Ажлын байрны тоо	Олгосон санхүүжилт /сая төгрөг/	Шинээр бий болсон ажлын байр
2017	Зорилтот бүлэгт чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр төслүүдийг шат дараатайгаар хэрэгжүүлэх	200	-	200	86	90.1	Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудын дунд "Ажилтай иргэн-Орлоготой өрх" ажлын хүрээнд 52 аж ахуйн нэгж оролцон 815 иргэн шинэ ажлын байртай болж, 180 иргэнийг түр ажлын байраар хангасан байна.
	"Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих" хөтөлбөр	123	123	-	-	-	Залуучуудын гарааны бизнесийг дэмжих Start-up арга хэмжээг Даланзадгад, Ханбогд суманд зохион байгуулж, 47 залуучуудыг дэмжин ажлын байраар хангажээ.
2018	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулах	200	200	-	91	113.4	"Оюу толгой" ХК-ий 62 иргэнийг ажлын байраар хангажээ. Мөн ажлын байранд зуучлах, сургалт зохион байгуулж, 754 иргэнийг ажлын байранд зуучлан, 415 иргэнийг түр ажлын байраар хангасан байна.
2019	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулах	150	150	-	110	101.2	Аймгийн төвүүдийн томоохон компаниудыг оролцуулан 90 иргэнийг ажлын байраар хангасан байна. 2019 оны байдлаар бүлгийн сургалтыг 351 хүнд зохион байгуулж, шинэ ажлын байранд 1003 хүн, түр ажлын байранд 50 иргэн, өссөн дүнгээр 720 хүн ажилд зуучлагдсан байна.
2020	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулах	280	280	-	188	217.5	Өрх гэр бүлийн хөгжлийн жилийн хүрээнд "Нэг өрх-нэг ажлын байр" программыг нэвтрүүлэн зорилтот бүлгийн хөдөлмөр эрхлэх боломжтой 130 иргэнийг ПТК-той хамтран үсчин, тогооч, оператор, хөдөлмөрийн аюулгүй байдлын мэргэжилтэн, гагнуурчин, оёдолчин зэрэг 11 төрлийн мэргэшүүлэх сургалтад хамруулан түр болон байнгын ажлын байранд 1292 иргэд оржээ.


“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

2021	"Өсөлтийг өрх бүрд" хөтөлбөр	-	-	-	193	248	Газар тариалан эрхлэх хүсэлтэй иргэдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 38 хүлэмжийг иргэдэд 50 хувийн хөнгөлөлттэй олгосон байна. Аймгийн хэмжээнд шинэ ажлын байр 1103, түр ажлын байраар 127 хүн хангагдаж 910 хүн ажлын байранд зуучлагдсан байна.
Дүн		953.0	753.0	200.0	668.0	770.2	

Эх сурвалж: Өмнөговь аймгийн Нийгмийн бодлогын хэлтэс

1.2 Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээний тооцооллыг аймгийн хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн систем LMIS программд шивж оруулсан байна.

График №1 Хөдөлмөрийн зах зээлийн статистик мэдээ



Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын “LMIS” программын судалгаанаас

1.3 Статистикаас харахад ажилгүй иргэдийн тоо 2021 онд өмнөх онуудтай харьцуулахад 8-914 иргэдээр, ажилгүйдлийн түвшин 2016-2018 онд 1.3-8.3 хувиар буурсан байна.

1.4 Ажлын шинэ байр 2016-2019 онуудад өссөн үзүүлэлтэй байгаа бол 2020-2021 онд цар тахлаас шалтгаалан буурсан байна.

1.5 Өмнөговь аймгийг 2016-2020 онд хөгжүүлэх “Бид хамтдаа”, 2020-2024 онд хөгжүүлэх “Нутгийн хишиг” боловсруулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2016 оны А/576, 2021 оны А/105 дугаар захирамжаар байгуулжээ.

1.6 Ажлын хэсэгт төр, төрийн бус байгууллага, бизнес эрхлэгчдийн төлөөлөл, иргэдийн төлөөллийг оролцуулан олон нийтийн дунд хэлэлцүүлэг хийж, иргэдийн санал хүсэлтийг тусган зохион байгуулсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг тооцоо судалгаанд үндэслээгүй байна

2.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг тусгасан төсвийн төслийн саналыг жил бүр Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын тушаалаар баталсан маягтын дагуу өмнөх оны батлагдсан төсөв, зардлын гүйцэтгэлд суурилан боловсруулдаг байна.

2.2 Санхүүжилтийн эх үүсвэрийг тооцоолсон суурь судалгаа, тооцоолол байхгүй байна.

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

2.3 Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл нь тухайн оны төсвийн саналыг нэгтгэн хэлэлцэж, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газраар дамжуулан аймаг, нийслэл, дүүрэгт хуваарилдаг байна.

2.4 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын байрыг нэмэгдүүлэх үйл ажиллагаанд 2016-2021 онд 5,034.2 сая төгрөгийг олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 4,703.7 сая төгрөгийг олгон 330.5 сая төгрөгийг дутуу санхүүжүүлсэн байна. /Хавсралт №1/

Төрийн байгууллагуудын чиг үүрэг харилцан уялдаатай байгаа боловч хяналт, шинжилгээ үнэлгээ үр дүнгүй байна

3.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2016-2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Засгийн газрын болон Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн баталсан хөтөлбөрүүд, аймгийн Засаг даргын Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын төсвийн Ерөнхийлөн захирагчтай хийсэн гэрээг үндэслэн баталсан байна.

3.2 Аймгийн Засаг даргын 2018 оны А/347, 2021 оны А/1151 дугаар захирамжуудаар аймгийн хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлийг 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

3.3 Аймгийн Засаг даргын 2021 оны А/1151 дугаар захирамжаар байгуулсан зөвлөлийн бүрэлдэхүүнд гэр бүл, залуучууд хөгжлийн газраас төлөөлөл оруулаагүй нь Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны “Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-ийн 2.2.7¹ дахь заалттай нийцээгүй байна.

3.4 Салбар зөвлөл нь 2017-2021 онд хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр баталсан хөтөлбөрүүд болон орон нутгийн онцлогтой хөтөлбөр төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтийг нь удирдан зохицуулах, биелэлтэд нь хяналт тавих, төслийн үр дүн нөлөөлөлд жил бүр үнэлгээ хийж, санал дүгнэлт гаргаагүй байна.

3.5 Энэ нь Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны “Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-ийн 2.1.4², 2.2.4³ дэх заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.6 Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний Ерөнхий газраас 2018 онд хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр хяналт, мониторингийн шалгалт хийж, дараах зөвлөмжийг өгсөн байна.

- Төсөл хөтөлбөрийн эргэн төлөлтөд хяналт тавин гэрээнд заасан хугацаанд багтаан төлүүлж байх,
- Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд явцын болон гүйцэтгэлийн хяналтыг тогтмол хийж, үр дүн үр нөлөөг тооцон хэрэгжээгүй төсөл арга хэмжээг буцаан татаж сангийн хөрөнгийн үр ашигтай байдлыг сайжруулахад анхаарч ажиллах,
- Төсөл хөтөлбөрийг сонгон шалгаруулахдаа зохих хууль журмын дагуу ашиг сонирхлын зөрчилгүй зохион байгуулах.

¹ Хөдөлмөр эрхлэлтийн асуудлаар төрийн захиргааны үйлчилгээний байгууллага, ялангуяа мэргэжлийн боловсрол, сургалт, жижиг дунд үйлдвэр, хөдөө аж ахуй, гэр бүл, залуучууд хөгжлийн болон бусад холбогдох асуудал эрхэлсэн байгууллага, бусад хороо зөвлөлүүдтэй үйл ажиллагаа уялдуулах.

² Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр батлагдсан хөтөлбөрүүд болон орон нутгийн онцлогтой хөтөлбөр төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтийг нь удирдан зохицуулах биелэлтэд нь хяналт тавих.

³ Тухайн орон нутагт хэрэгжсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээ, хөтөлбөр төслийн үр дүн нөлөөлөлд жил бүр үнэлгээ хийж, санал дүгнэлт гаргах.

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

3.7 Зөвлөмжийн хүрээнд 15 сумаас хугацаа хэтэрсэн зээл 157.8 сая төгрөгийг барагдуулахаар сумдын Засаг дарга, цагдаагийн хэсгийн төлөөлөгч нараар дамжуулан “Мэдэгдэх хуудас” өгч хамтран ажиллаж зээлийг барагдуулж ажилласан байна.

3.8 Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан 2 ахлах мэргэжилтэн ажиллаж, 2016-2021 оны хөтөлбөр арга хэмжээнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн байна. /Хавсралт №2/

3.9 Удирдамжийн дагуу хяналт хийж тайлан бичиж байгаа боловч алдаа зөрчлийг нэгтгэсэн хүснэгт, дүн шинжилгээ, судалгаа байхгүй байна.

3.10 Зөрчил гаргаж байгаа этгээдэд холбогдох хууль журмын дагуу хариуцлага тооцдоггүй, зээлийг эргүүлэн татах талаар ямар нэгэн арга хэмжээ авдаггүй байна.

3.11 Энэ нь Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 5.1.3⁴ дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.12 Мөн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны үр дүнд хөндлөнгийн байгууллагаар 2017-2021 онд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийлгээгүй байгаа нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2⁵ заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.13 Эдгээрээс харахад хяналт, шинжилгээ үнэлгээг үр дүнтэй хийж, ажлыг сайжруулах шаардлагатай байна.

БҮЛЭГ 2 Хөтөлбөрийн санхүүжилтийг хэт бага дүнгээр хуваан олгож байгаа нь хөтөлбөрийн үр дүнг бууруулж байна

4.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 8.2⁶, 8.3⁷-д заасны дагуу ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажилд зуучлах арга хэмжээг ганцаарчилсан болон бүлгээр зохион байгуулсан байна.

Хүснэгт №-2. ХХҮГ-н ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, ажилд зуучлах үйлчилгээ байдал

№	Төсөл, хөтөлбөрийн нэр	2016 он		2017 он		2018 он		2019 он		2020 он		2021 он		Нийт дүн /сая төгрөг/	Нийт хамрагдсан иргэдийн тоо
		Хамрагдсан иргэн	Олгосон санхүүжилт /сая төгрөг/	Хамрагдсан иргэн	Олгосон санхүүжилт /сая төгрөг/	Хамрагдсан иргэн	Олгосон санхүүжилт /сая төгрөг/	Хамрагдсан иргэн	Олгосон санхүүжилт /сая төгрөг/	Хамрагдсан иргэн	Олгосон санхүүжилт /сая төгрөг/	Хамрагдсан иргэн	Олгосон санхүүжилт /сая төгрөг/		
1	Ажилд зуучлах үйлчилгээ	806	3.6	770	10.2	918	9.1	1,235	7.5	1,049	1.5	798	2.2	34.1	5,576

⁴ Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлтээр зөвлөмж өгөх, өгсөн зөвлөмжийг хангалтгүй биелүүлсэн албан тушаалтанд хариуцлага тооцох саналыг эрх бүхий албан тушаалтанд гаргах.

⁵ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны үр дүнд хөндлөнгийн байгууллагаар жил бүр хяналт, шинжилгээ, үнэлгээ хийлгэнэ.

⁶ Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжлийн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээг ганцаарчлан болон хэсэг, бүлгээр зохион байгуулна

⁷ Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээг тухайн сургуулийн захиргаатай хамтран тусгайлсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулна. ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажилд зуучлах арга хэмжээг ганцаарчилсан болон бүлгээр зохион байгуулсан байна

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

2	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ	825	9.9	938	7.8	1,100	9.2	1,550	10.8	618	4.7	333	5.0	47.4	5,364
Нийт		1,631	13.5	1,708	18.0	2,018	18.3	2,785	18.3	1,667	6.2	1,131	7.2	81.5	10,940

Эх сурвалж: Өмнөговь аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газар

4.2 Судалгаанаас харахад ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажилд зуучлах арга хэмжээнд хамрагдсан хүний тоо жил бүр өссөн байгаа нь сургалт мэдээлэл үр дүнтэй зохион байгуулагдаж байгааг харуулж байна.

4.3 Ажил олоход хүндрэлтэй, идэвхтэй ажил хайгч болон зорилтод бүлгийн иргэдэд ямар нөхцөл боломж байгаа түүнийг хэрхэн ашиглах, өөрт тулгарч байгаа саад бэрхшээлийг хэрхэн даван туулах, эерэг хандлага олгох, ажлын анкет хэрхэн бөглөх талаар сургалт зөвлөгөө үйлчилгээг үзүүлсэн байна.

4.4 Ковид-19 цар тахал өвчний улмаас сургалт зөвлөгөөний тоо буурсан байна.

Хүснэгт №-3 Ганцаарчилсан сургалтад хамрагдсан байдал

Он	Магистр, доктор	Дипломын болон бакалавр	Тусгай мэргэжлийн дунд	Техникийн болон мэргэжлийн анхан шатны	Бүрэн дунд	Суурь	Бага	Боловсролгүй
2016	0	62	23	12	67	5	2	1
2017	1	100	46	31	184	9	3	1
2018	2	106	24	25	274	9	3	10
2019	3	67	21	19	330	5	5	3
2020	1	97	28	33	319	11	5	3
2021	0	101	29	24	222	12	7	0
дүн	7	533	171	144	1396	51	25	18

Эх сурвалж: Өмнөговь аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газар

4.5 Сургалтын үйл ажиллагаа явуулдаг байгууллагатай хамтран хөдөлмөрийн зах зээл гэж юу болох, өөрийн сонирхсон мэргэжил нь зах зээл дээр эрэлт нийлүүлэлт хэр байгаа, тухайн мэргэжлийн ур чадвар, онцлог нь өөрт хэрхэн нийцэж байгаа талаар аймгийн болон сумдын төгсөх ангийн сурагчдад танхимын болон цахим сургалт зөвлөгөөнийг жил бүр зохион байгуулсан байна.

4.6 Мөн ЕБС-н дунд болон ахлах бүлгийн сурагчдад **mergejil.mn** сайтын танилцуулга гарын авлагыг бэлтгэн тараасан байна.

Хүснэгт №-4 Бүлгийн сургалтад хамрагдсан байдал

Он	Ажил хайгч	Ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн	Ажил олоход хүндрэлтэй иргэн	ЕБС-н сурагч	Их дээд сургууль, коллеж, МСҮТ төгсөгч	Ажилтан албан хаагч	ХБИ	Нийт дүн
2016	0	0	0	0	0	0	0	0
2017	0	0	55	420	27	116	35	618
2018	351	1	0	100	1			453
2019	21	34	128	712	21	123	82	1039
2020	96	0	48	0	0		0	144
2021	25	0	0	641	0	0	0	666
дүн	493	35	231	1873	49	239	117	2920

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

Эх сурвалж: Өмнөговь аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газар


4.7 Тус газар нь ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажилд зуучлах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллажээ.

Нэгдсэн бүртгэл, мэдээллийн системийг бүрэн ашиглаж байна

4.8 Хөдөлмөр халамж үйлчилгээний газар нь хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн систем болох LMIS программд аймгийн хэмжээний нийт ажил олгогчдын ажиллах хүч, ажлын байрны мэдээллийг оруулсан байна.

4.9 Программын шинэчлэлт баяжуулалтыг сар бүр хийж, мэдээ тайлан тоон үзүүлэлтийг нэгтгэн тайлагнасан байна.

График №-2 Ажлын байранд бүртгэлтэй болон ажилд зуучлагдсан иргэд



Эх сурвалж: Өмнөговь аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газар

4.10 Тус байгууллага нь 2016-2021 онд аймгийн хэмжээнд 6799 ажилгүй иргэнийг бүртгэн, 5576 иргэнийг ажлын байранд зуучилсан байна.

4.11 Дээрх судалгаанаас үзэхэд шинээр ажил хайж бүртгүүлсэн иргэдийн тоо өсөж үүнийг дагаад ажлын байранд зуучлагдсан иргэдийн тоо нэмэгдсэн байна.

4.12 Хөдөлмөрийн хэлтсийн мэдээллийн санд 2022 оны 1 дугаар улирлын байдлаар бүртгэлтэй ажил идэвхтэй хайж байгаа 353 иргэн байгаа бөгөөд 3 дугаар сард 141 хүн шинээр бүртгэгдэж, 56 иргэн ажилд орж, бүртгэлээ сэргээсэн 156 иргэн байна.

4.13 Шинээр бий болж байгаа ажлын байрны зарыг ААН, байгууллагуудаас сар бүр авч, хөдөлмөрийн хэлтсийн Веб сайт <http://omnogovi.hudulmur-halamj.gov.mn/>, <http://eoffice.omnogovi.gov.mn/login>, <https://www.facebook.com/Omnogovi.HHUGazar/>, Даланзадгад сумын багийн төвүүд, аймаг дахь МОНЦАМЭ агентлаг, Говийн наран телевиз, Алтанговь, USTV зэрэг орон нутгийн гэрээт телевизүүдээр мэдээ мэдээллийг өгч олон нийтэд хүргэсэн байна.

Хөдөлмөрийн бирж :

4.14 Аймгийн хэмжээнд “Арвин эрдэнэ” ХХК 2008 оноос эхлэн сургалтын зохион байгуулах, хөдөлмөр зуучлал гэсэн 2 үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

4.15 Ажил хайгч иргэд болон ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажилд зуучлах арга хэмжээг ганцаарчилсан болон бүлгийн хэлбэрээр зохион байгуулан ажлын байранд зуучлан түүний үр дүнгээр ХХҮЕГ-аас урамшуулал, санхүүжилт авсан байна.

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

4.16 Мөн нэмэлтээр мэргэжлийн боловсрол сургалтын үнэлгээ аргазүйн төвөөс сургалт зохион байгуулах эрхийн гэрчилгээг авч бизнес эхэл, мод бут цэцэрлэгжүүлэлт, хүлэмжийн аж ахуй, худалдааны газрын үндсэн ажилтан бэлтгэх гэсэн чиглэлээр сургалтын үйл ажиллагаа явуулсан байна.

4.17 Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн туслан гүйцэтгэгч компанийн төлөөлөл болон шинээр ажлын байр бий болж байгаа аж ахуй нэгж компаниудтай хамтран ажиллах санал солилцож одоогоор 29 байгууллага, аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан ажиллаж байна.

Хүснэгт №-5 Хөдөлмөрийн биржийн үйлчилгээ үзүүлсэн байдал

Он	Бүртгэсэн хүний тоо	Ажилд зуучилсан хүний тоо	Авсан санхүүжилт	Ганцаарчилсан		Бүлгийн	
				Сургалтад хамрагдсан хүний тоо	Үүнээс: эмэгтэй	Сургалтад хамрагдсан хүний тоо	Үүнээс: эмэгтэй
2018	327	84	1,9	71	29	0	0
2019	1195	255	13,0	504	264	1095	657
2020	950	110	16.3	232	130	131	85
2021	732	131	23.0	207	74	666	434

Эх сурвалж: Хөдөлмөрийн бирж

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд зарцуулсан хөрөнгийн үр ашгийг тооцож, тайлагнасан байна

4.18 Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд 2016-2021 онд нийт 81.5 сая төгрөг зарцуулан 10940 иргэн хамрагдсан байна. Нийтлэг үйлчилгээний жишиг зардлыг Нийгэм хамгаалал хөдөлмөрийн сайдын тушаалаар жил бүр баталсан байна.

4.19 Тус санхүүжилтийг зөвшөөрөл бүхий байгууллагаар сургалт зохион байгуулан иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ, ажилд зуучлах үйлчилгээг үзүүлэхэд зарцуулсан байна.

4.20 Орон нутагт шинээр бий болсон ажлын байрны мэдээг гаргуулан авч хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл мэдээллийн санд бүртгэж ажилласан байна.

5. Дэлхийн банкны санхүүжилтээр “Бичил бизнесийг дэмжих” хөтөлбөрийг хэрэгжүүлж ажилласан байна.

5.1 Дэлхийн банкнаас тогтоосон зээл олгох шалгуур үзүүлэлтийн дагуу ХХҮГ-н даргын тушаалаар томилогдсон ажлын хэсэг үнэлж 3-н шатлалаар дүгнэж шалгаруулан арилжааны банк руу хүсэлт хүргүүлсэн байна.

5.2 Зээлийг Хаан банкаар дамжуулан ХХҮГ, Хаан банк, иргэний гурвалсан гэрээ байгуулан жилийн 7.2 хувийн хүүтэй 24 сарын хугацаатайгаар олгосон байна.

5.3 Тус зээлийн олгох нөхцөл, шалгуур, бүрдүүлэх материал, барьцаа хөрөнгийн хэмжээ, тавигдах шаардлага өндөр байдаг нь иргэдэд хүндрэлтэй, хамрагдах хүний тоо цөөн байдаг байна.

5.4 Бичил бизнесийг дэмжих зээлийг 2019 оноос эхлэх 2022 хүртэл 34 иргэнд 12 чиглэлээр 313.0 сая төгрөгийн зээл олгож шинээр 63 ажлын байр нэмэгдсэн байна.

Хөтөлбөрүүдийн хэрэгжилт, зээлийн эргэн төлөлтөд тавих хяналт хангалтгүй байгаа нь хөтөлбөрийн үр дүнг бууруулж байна.

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр:

5.5 Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлэх, ажилд дадлагажуулан зуучлах цогц үйлчилгээг туршин нэвтрүүлэх болон аж ахуй эрхлэх бүтээлч, шинэлэг санаа, санаачилгыг дэмжихэд зориулан санхүүгийн дэмжлэг олгосон байна.

5.6 Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2017-2021 онуудад 28 иргэнд 185.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгожээ.

5.7 Үүнээс сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, үйл ажиллагаа явуулаагүй 7 иргэний 22.7 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлт хийгдээгүй байна.

График №-3 Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хэрэгжүүлэгчийг үйл ажиллагааны чиглэл



Эх сурвалж: Өмнөговь аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газар

5.8 Уг хөтөлбөрт хамрагдсан зарим иргэн, аж ахуй нэгжүүд эргэлтийн хөрөнгөө нэмэгдүүлэхэд зарцуулсан, зарим нь үйл ажиллагаа явуулаагүй байна. Тухайлбал:

- “Кино” төслөөр 10.0 сая төгрөг олгосон төслийн хэрэгжилттэй танилцахад ажлын байр байхгүй, үйл ажиллагаа явуулаагүй,
- Гоо сайхны чиглэлээр үйл ажиллагаа явуулах зориулалтаар 10.0 сая төгрөгийг зээл авсан боловч HERBALIFE-н эрүүл хооллолтын клубийн үйл ажиллагаа явуулж зориулалт бусаар зарцуулсан, программ бүтээх чиглэлээр 10.0 сая төгрөг авсан боловч зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн эргэн холбогдох утасны дугаар, хаяг тодорхойгүй, үйл ажиллагаа явуулахгүй байна.

5.9 Зарим төсөл хэрэгжүүлэгч зээлийг зориулалтын дагуу дагуу үр ашигтай ашиглан хэрэгцээтэй тоног төхөөрөмж худалдан авч, шинээр ажлын байр бий болгосон сайн талтай байна.

Зураг №-1 Иргэн Х.Тэгш-амгаланд олгосон төсөл хөтөлбөрийн хэрэгжилт



“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

Шилдэг Start-up залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох хөтөлбөр:

5.10 Шилдэг Start-up хөтөлбөрийн хүрээнд 2021 онд гэрлийн дулаанаар хүнсний ногоо тариалах чиглэлээр төсөл шалгаруулан 10.0 сая төгрөгийн эргэн төлөлтгүй дэмжлэг үзүүлсэн байна.

5.11 Төслийн явцтай танилцахад хөрөнгийн зарцуулалт тодорхой бус, хүнсний дэлгүүрийн агуулахын өрөөнд цөөн тооны үрсэлгээ хийж байгаа нь төслийн шалгаруулалт болон хэрэгжилт үр дүнгүй байгааг харуулж байна.

Зураг №-2 Гэрлийн дулаанаар хөрсгүй тариалалт




Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр:

5.12 Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2016-2021 онуудад 196 иргэнд 898.7 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон байна.

5.13 Мал маллах хүсэл эрмэлзэлтэй залуусыг малжуулах, монголын уламжлалт мал аж ахуйг хөгжүүлэх зорилго бүхий энэ хөтөлбөрт анх 15-39 насныхан хамрагддаг байсан бол 2019 оноос өөрчлөлт орж 15-45 насны иргэд хамрагдахаар болсон байна.

График №-4 Малчдын хөдөлмөр эрхлэлтэд зарцуулсан хөрөнгө, хамрагдсан иргэн



Эх сурвалж: Өмнөговь аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газар

5.14 Тус санхүүгийн дэмжлэгийг хүүгүй олгодог учир иргэдийг малжуулахад үр дүнтэй, зээл авах сонирхолтой иргэдийн тоо их байдаг байна.

5.15 Малжуулах арга хэмжээнд хамрагдсан өрхүүд 11980 толгой мал худалдан авсан байна.


“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр:

5.16 Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг зөвхөн хувиараа аж ахуй эрхэлж орлогоо нэмэгдүүлэх чиглэлийг барьж олгож байгаа хөтөлбөрийн зорилтыг бүрэн хангаагүй байна.

5.17 Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2017-2021 онуудад 46 ахмадад 92.5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон байна.


График№-5 Ахмад настны хөдөлмөр эрхлэлтэд зарцуулсан хөрөнгө, хамрагдсан иргэн



Эх сурвалж: Өмнөговь аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газар

5.18 ХЭДС-ийн баталсан төлөвлөгөөгөөр 32 иргэн хамруулахаас 46 иргэний төсөл хөтөлбөрийг сонгон шалгаруулж 1.0-3.0 сая төгрөгийн хооронд жижиглэн олгосон байна.

Дүрлэл № 1 Хөтөлбөрт хамрагдсан ахмадын хөдөлмөр эрхлэлтийн байдал



5.19 Үүнээс харахад хөтөлбөрт хамрагдсан иргэдийн 26 хувь нь үйл ажиллагаа явуулахгүй байна. Энэ нь хөтөлбөрийн үр өгөөжийг бууруулж байна.


5.20 Ахмад мэргэжилтнүүдийн ажил хөдөлмөрт бэлтгэх оролцоог нэмэгдүүлж, тэдний мэдлэг, ажлын туршлагыг өсвөр хойч, залуу үеийнхэнд өвлүүлэх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх чиглэлээр төсөл хөтөлбөрт түлхүү хамруулах нь илүү үр дүнд хүрэхээр байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр:

5.21 Уг хөтөлбөрийн хүрээнд 2017-2021 онуудад 94 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 225.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосноос 2020-2021 онуудад 50 хувийн эргэн төлөлт хийхээр гэрээ байгуулж олгосон байна.

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

График №6 ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтэд зарцуулсан хөрөнгө, хамрагдсан иргэн



Эх сурвалж: Өмнөговь аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газар

5.22 Мөн баталсан төлөвлөгөөний дагуу 51 иргэн хамруулахаас 94 төсөл хөтөлбөр сонгон шалгаруулж 1.0-5.0 сая төгрөгийн хооронд жижиглэн олгосон байна.

Дүрслэл №2 Хөтөлбөрт хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал



5.23 Үүнээс сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, үйл ажиллагаагаа зогсоосон 25 иргэний 41.3 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт хийгдээгүй, сангийн хөрөнгийг буцаан төвлөрүүлээгүй байна.

5.24 Хөтөлбөрт хамрагдсан иргэдийн 28.7 хувь нь үйл ажиллагаа явуулахгүй байна.

5.25 Цаашид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлогт тохирсон тусгайлан ажлын байрыг бий болгох тогтвортой ажиллуулах орчин, нөхцөлийг бүрдүүлэх, тэдэнд ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэх арга хэмжээг идэвхжүүлэх шаардлагатай байна.

Орон нутгийн онцлогт тохирсон төсөл:

5.26 Хөтөлбөрийн зорилго нь зах зээл дээр үнэгүйдэж буй арьс нэхийний үнийг өсгөх, мал, малын гаралтай түүхий эдийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, орон нутагт ажлын байр шинээр бий болгох, малчин иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, арьс нэхийг бүрэн боловсруулж нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, орон нутгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулахад оршино.

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

5.27 Уг хөтөлбөрийн хүрээнд Цогт-Овоо сумын “Монсор Илч” ХХК-ны хонины нэхий боловсруулах үйлдвэрлэлийн төслийг 2018 оны 11 сараас 2021 оны 11 сар хүртэлх хугацаанд хэрэгжүүлсэн байна.

5.28 Орон нутгийн онцлогт тохирсон төслийг ХХҮЕГ-аас сонгон шалгаруулж 100.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 3 жилийн хугацаанд эргэн төлөгдөхөөр олгосон байна.


5.29 Төслийг хэрэгжүүлэгч 5 иргэнийг ажлыг байраар хангаж ажилласан боловч цар тахлын улмаас хил хаагдаж боловсруулах үйлдвэрийн химийн бодисоо татаж авах болон бусад шалтгаанаар 2020-2021 онд үйлдвэрлэл эрхлээгүй байна.

5.30 Үйл ажиллагаа хэвийн явагдаагүйгээс 66.8 сая төгрөгийг хугацаандаа эргэн төлөөгүй байна.

35-аас дээш насны иргэдийн ажлын байрыг дэмжих хөтөлбөр:

5.31 Хөтөлбөрийн хүрээнд 2017-2021 онуудад 217 иргэнд 724.1 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон байна.


График №-7 35-аас дээш насны хөдөлмөр эрхлэлтэд зарцуулсан хөрөнгө, хамрагдсан иргэн



Эх сурвалж: Өмнөговь аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газар

5.32 Батлагдсан төлөвлөгөөний дагуу 206 иргэн хамруулахаас 217 төсөл хөтөлбөр сонгон шалгаруулж 1.0-5.0 сая төгрөгийн хооронд жижиглэн олгосон байна.

Дүрслэл №3 Хөтөлбөрт хамрагдсан 35-аас дээш насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал



5.33 Үүнээс сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, үйл ажиллагаагаа зогсоосон 59 иргэний эргэн төлөлт хийгдээгүй 129.7 сая төгрөг байна.

Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар зохион байгуулсан арга хэмжээ байхгүй байна

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

5.34 Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2016-2021 онуудад тусгай арга хэмжээ, хөтөлбөр зохион байгуулаагүй байна.

5.35 Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт, 35-аас дээш насны иргэдийн ажлын байрыг дэмжих, ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдэд 2016-2021 онуудад 581 иргэн хамрагдсанаас 194 буюу 33.4 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.


5.36 Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 46.4 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа нь эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хөтөлбөр хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байгааг харуулж байна.

5.37 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж байгаа хөтөлбөрүүдийн санхүүжилтийг хэт жижиглэн олон чанаргүй төсөл шалгаруулж, түүнийг хэрэгжилт, эргэн төлөлтөд тавих хяналт хангалтгүй байгаа нь хөтөлбөрийн үр дүнг бууруулж байна.

6. Орон нутгийн төсвөөс хуваарилах хөрөнгийг дэд санд төвлөрүүлээгүй байна

6.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль болон МУЗГ-ын 2011 оны 375 дугаар тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-д заасны дагуу бүрдүүлсэн байна.

График №-8 Өмнөговь аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого 2016-2021 оны байдлаар /сая төгрөгөөр/



Эх сурвалж: Өмнөговь аймгийн ХХҮГ-ын ХЭДС-ийн 2016-2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

6.2 Өмнөговь аймгийн ХЭДС-ийн орлогыг 2018 оны орлоготой харьцуулахад 2019 онд 67.9, 2020 онд 324.0 хувиар, 2021 онд 506.2 хувиар тус тус өссөн нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөрийн хэмжээг 2019 оноос хойш тухайн байгууллагад ажиллагчдын дундаж цалингийн 60 хувиар тооцож төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт №-6 ХЭДС-ийн орлогыг эх үүсвэр

/сая төгрөгөөр/

Орлогын эх үүсвэр	2016	2017	2018	2019	2020	2021	Хувь
Улсын төсвөөс хуваарилсан	692.0	788.0	853.5	369.0	409.5	765.3	25.3
Орон нутгийн төсвөөс хуваарилсан		214.0					1.4
Гадаад улс, олон улсын байгууллага					10.5	2.1	0.1
ХБИ ажиллуулаагүй аж ахуй нэгж байгууллагын төлбөр	56.8	137.6	138.3	789.4	3,211.3	4,991.6	60.9

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөгдсөн	70.3	151.2	209.1	362.0	261.9	322.9	9.0
Бусад эх үүсвэр		0.3	0.6	497.7			3.3
ХЭДС-ийн орлогын нийт дүн	819.1	1,291.2	1,201.5	2,018.2	3,893.4	6,082.0	100


Эх сурвалж: Өмнөговь аймгийн ХХҮГ-ын ХЭДС-ийн 2016-2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

6.3 МУЗГ-ын 2011 оны 375 дугаар тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын дагуу дэд санд аймгийн төсвөөс жил бүр олгох хөрөнгийн хэмжээ нь тухайн төсвийн орлогын 0.3 хувиас доошгүй байна гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

6.4 Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.3-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас “Аж ахуй нэгж, байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй орон тоо тутамд сар бүр төлөх төлбөрийн хэмжээ”-г 2019 оны 111 дугаар тогтоолоор шинэчлэн тогтоосон байна.

6.5 Аж ахуй нэгж, байгууллагаас Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2-д заасны дагуу хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлсэн хөрөнгө дараах байдалтай байна.

График №-9 Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийн орлого /сая төгрөг/



Эх сурвалж: Өмнөговь аймгийн ХЭДС-ийн 2016-2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

6.6 Графикаас харахад хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл харилцан уялдаагүй хэт өндөр зөрүүтэй байгаа нь орлогын эх үүсвэрийг бодитой төлөвлөж, бүрэн төвлөрүүлж ажиллаагүйг харуулж байна.

Хүснэгт №-7 Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөр төлсөн аж ахуй нэгж байгууллага

/сая төгрөг/

Он	ААНБ-ын тоо	Төлбөр төлсөн хүний тоо	Төвлөрүүлсэн мөнгөн дүн
2016	7	8	56.8
2017	12		137.6
2018	12		138.3
2019	12	685	789.4
2020	17	214	3,211.3
2021	14	852	4,991.6
Нийт дүн	43	1759	9,325.0

Эх сурвалж: Өмнөговь аймгийн ХХҮГ


6.7 Аймгийн ХХҮГ-т аж ахуй нэгж, байгууллага, ажиллагсдын тоо бүртгэл мэдээллийн сан байхгүйгээс аж ахуй нэгж, байгууллагад төлбөр ногдуулдаггүй бөгөөд сангийн орлогод төвлөрсөн хөрөнгийг гүйцэтгэлээр тайлагнасан байна.

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

6.8 Шалгагдагч этгээдээс 2017, 2018 онуудад төлбөр төлөгдсөн хүний тоон мэдээлэл ирүүлээгүй.

6.9 Аймгийн ХЭДС-д 2021 оны жилийн эцсийн байдлаар хөтөлбөртэй холбоотой 970.1 сая төгрөгийн авлага байгаагаас хугацаандаа эргэн төлөгдөөгүй санхүүгийн дэмжлэг 227.0 сая төгрөг буюу 23.4 хувийг эзэлж байна.

График №-10 Санхүүгийн дэмжлэгийн хугацаандаа эргэн төлөгдөөгүй хөрөнгө /2016-2021/ /сая төгрөг/



Эх сурвалж: Өмнөговь аймгийн ХХҮГ

6.10 Аймгийн ХЭДС-д жижиг зээл болон эргэн төлөгдөх хөрөнгө 227.0 сая төгрөгөөр дутуу төвлөрсөн байна.

Сангийн хөрөнгийг хууль журмын дагуу орон нутгийн онцлогт тохируулан зарцуулсан ч хөтөлбөрүүдийн үр дүнг тооцоогүй байна

6.11 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд ажил хайгч, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн, малчин, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон ажил олгогчийг хуульд заасны дагуу хамруулсан байна.

6.12 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль болон МУЗГ-ын 2011 оны 375 дугаар тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-д заасны дагуу зарцуулж ажилласан байна.

6.13 ХЭДС-ийн хөрөнгийн 7.6 хувийг хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд, 92.4 хувийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд зарцуулсан байна.

Хүснэгт №-8 Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих үйл ажиллагаанд зарцуулсан нийт хөрөнгө 2016-2021 он /сая төгрөг/

Үйл ажиллагааны төрөл	Нийтлэг үйлчилгээ, төсөл хөтөлбөрийн хэлбэр	Зарцуулсан хөрөнгө /сая төгрөг/	Зардлын гүйцэтгэлд эзлэх хувь
Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ	Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах	47.4	1.2
	Ажилд зуучлах үйлчилгээ	34.4	0.9
	Ажилгүйдлийн тэтгэмж олгох	0	-
	Нэгдсэн бүртгэл, мэдээллийн үйлчилгээнд хамруулах	37.7	1.0
	Бусад үйлчилгээ	168.4	4.4
	Дүн	287.9	7.6
	Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ	14.6	0.3
	Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах	95.2	2.5

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ	Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нөхөрлөл хоршоо байгуулах иргэнийг дэмжих	2128.6	56.3
	Ажил олгогчийг дэмжих	125.7	3.3
	Нийтийг хамарсан ажил зохион байгуулах	322.2	8.5
	Ажил олоход хүндрэлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	444.5	11.7
	ХЭҮЗ-ийн шийдвэрээр тодорхойлсон төсөл хөтөлбөр	355.8	9.4
	Дүн	3486.6	92.3
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны зардлын нийт дүн		3774.5	100

Эх сурвалж: Өмнөговь аймгийн ХЭДС-ийн 2016-2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

6.14 Дээрхээс харахад сангийн хөрөнгийн 56.4 хувийг малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг дэмжихэд зориулж эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр олгосон санхүүгийн дэмжлэгийн арга хэмжээ эзэлж байна.

6.15 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг дараах үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Хүснэгт №-9 ХЭДС-ийн хөрөнгийн төсвийн гүйцэтгэл 2016-2021 оны нэгдсэн байдлаар

/сая төгрөг/

Хөтөлбөр, төслийн ангилал	Төлөвлөгөө		Гүйцэтгэл	
	Хүн	Мөнгөн дүн	Хүн	Мөнгөн дүн
<u>Зарцуулалт: ДҮН</u>	3022	4,558.4	18960	15,305.8
Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээ хангах үйлчилгээ	5165	49.69	5364	47.4
Ажилд зуучлах үйлчилгээ	2977	36.6	4177	34.4
Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох, ажлын байр хадгалах хөтөлбөр	630	121.4	680	107.1
Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	2444	1,774.7	2879	1,441.3
Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	333	354.3	357	267.5
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	457	380.6	444	324.6
Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	573	919.2	441	849.6
Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	154	160.8	127	139.9
Хүүгийн хөнгөлөлт	15	10.2	1	0.6
Засгийн газар, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, бусад шийдвэрээр тодорхойлсон хөтөлбөр төслийн санхүүжилт	4	55.4	238	36.7
Хөдөлмөрийн салбарын ажилтнуудын сургалт	-	42.0	272	40.5
Бүртгэл мэдээллийн сүлжээ ажиллуулах	-	37.8	48	37.6
Сурталчилгаа, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах	-	41.3	1525	38.2
Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл	-	23.0	50	21.8
Хөдөлмөрийн харилцаа, үндсэн эрхийн хэрэгжилт	-	14.6	595	14.1
Хөтөлбөр төслийн хяналт үнэлгээ	-	49.9	16	35.3
Гарын авлага хэвлэмэл материал	-	19.8	1420	18.1
Орон нутгийн онцлогт тохирсон төслийн санхүүжилт	-	100.0	1	100.0
Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр	185	18.6	89	4.9
Бусад хөтөлбөр төслийн санхүүжилт	-	214.0	163	214.0
Татаас, шилжүүлэг	-	-	-	11,397.4
Өглөг барагдуулахад	85	133.8	73	133.8

Эх сурвалж: Өмнөговь аймгийн ХЭДС-ийн 2016-2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

6.16 Дээрх хүснэгтээс харахад 11,397.4 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн нь аж ахуй нэгж байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийн гүйцэтгэлтэй холбоотой байна.

6.17 Энэхүү төлбөрийг хуульд заасны дагуу тухайн орлогыг бүрдүүлсэн орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулна гэж заасан боловч хэрэгжээгүй байна.

6.18 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг дэмжих төсөл хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө дараах байдалтай байна.

Хүснэгт №10 ХЭДС-аас төсөл хөтөлбөрүүдэд зарцуулсан хөрөнгө

Хөтөлбөрийн ангилал	Хөтөлбөрт хамрагдсан хүний тоо	Зарцуулсан хөрөнгө /сая төгрөг/	Бий болсон ажлын байрын тоо
Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	441	849.6	361
35 -аас дээш насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	2879	1,441.4	247
Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	357	267.5	20
Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	127	139.9	44
ХБИ хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	444	324.6	82
Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээ	12	110	25
Дүн	4260	3,133.0	769

Эх сурвалж: Өмнөговь аймгийн ХХҮГ ХЭДС 2016-2021 он

6.19 Хүснэгтээс харахад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөр, арга хэмжээнд 4260 хүн хамрагдаж 3,133.0 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан бөгөөд хөтөлбөрийн хүрээнд бий болгосон байнгын ажлын байр 769 байгаа нь санхүүгийн дэмжлэг бага, урт хугацаанд хэрэгжиж, ажлын байр хадгалах боломжгүй, зах зээлийн эрэлт, хэрэгцээ шаардлагыг хангаагүй жижиг төсөл хөтөлбөрийг санхүүжүүлсэнтэй холбоотой байна.

6.20 Санхүүгийн дэмжлэгийг хүүгүй, барьцаагүй, Монгол банкны мэдээллийн санд оруулахгүй олгож байгаа нь төсөл хөтөлбөрт хамрагдагчид сайн тал бий болж байгаа хэдий ч төрийн өмч, хөрөнгийг үнэгүйдүүлэх эрсдэлийг бий болгож байна.

6.21 Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоолоор жил бүр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн зорилт, хэрэгжүүлэх арга замыг заахдаа санхүүгийн дэмжлэгийн хэмжээг 3 сая, 5 сая төгрөг хүртэл гэж заасан нь төсөл сонгон шалгаруулах ажлын хэсэг санхүүжилтийг бууруулж хамрах хүрээг нэмэх суурь шалтгаан болжээ.

6.22 Өмнөговь аймгийн ажилгүйдлийн түвшин, хөдөлмөр эрхлэлтийг сүүлийн 6 жилээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №11 Ажилгүйдлийн түвшин ба хөдөлмөр эрхлэлтийн судалгаа

/хувиар/

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020	2021
Ажилгүйдлийн түвшин	14.3	16.4	7.3	6.0	5.6	6.0
Хөдөлмөр эрхлэлт	59.1	57.5	64	66.7	67.8	57.5

Эх сурвалж: Өмнөговь аймгийн ХХҮГ

6.23 Ажилгүйдлийн түвшин сүүлийн 6 жилд 8.4 хувиар буурсан, хөдөлмөр эрхлэлт 8.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”


6.24 Энэ нь төрөөс хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд болон орон нутагт уул уурхайн салбар хөгжиж шинээр ажлын байр бий болсонтой холбоотой байна.

7. Мэргэжлийн боловсрол олгох сургалтын байгууллагаас хөдөлмөрт бэлтгэх үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлсэн байна

7.1 Өмнөговь аймгийн Политехникийн коллеж нь “Бүс нутгийн хөгжлийн бодлого, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн ажил олгогчийн хэрэгцээ шаардлагыг хангах мэдлэг, ур чадвар, хандлага бүхий мэргэжилтэй ажилчдыг бэлтгэн нийлүүлнэ” гэсэн зорилготойгоор дипломын сургалт, мэргэжлийн боловсрол олгох сургалт, мэргэжлийн сургалт, богино хугацааны чадамж эзэмшүүлэх сургалтыг явуулж иржээ.

График №-11 Мэргэжлийн сургалтын байгууллагад олгосон санхүүгийн дэмжлэг

/сая төгрөг/



Эх сурвалж: Өмнөговь аймгийн Политехникийн коллежийн 2016-2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

7.2 Дээрхээс харахад төсвийн санхүүжилт тогтмол өссөн бөгөөд санхүүжилтийн эх үүсвэрийн 98 хувийг улсын төсөв, 2 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлогоос бүрдүүлж байна.

7.3 Богино хугацааны чадамж эзэмшүүлэх төлбөртэй сургалтыг аймгийн ЗДТГ, ХХҮГ, уул уурхайн компани, аж ахуй нэгжийн захиалгаар явуулж төсвийн байгууллагын үйл ажиллагааны орлогод 21.1-29.9 сая төгрөг төвлөрүүлэн ажиллажээ.

График №-12 Өмнөговь аймгийн Политехникийн коллежийн төсвийн зардлын гүйцэтгэлийг нэр төрлөөр хувиар харуулбал:



Эх сурвалж: Өмнөговь аймгийн Политехникийн коллежийн 2016-2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

7.4 Баталсан төсвийг 100 хувь урсгал зардалд зарцуулж ажилласан ба нийт зардлын 68.4 хувийг цалин нэмэгдэл хөлс, ажил олгогчоос төлөх НДШ-ийн төлбөр эзэлж байна.

7.5 Өмнөговь аймгийн Политехникийн коллеж нь 2016-2021 онд нийт 1247 төгсөгчдийг 21 мэргэжлээр сургаж төгсгөсөн байна.

Хүснэгт №-12 Мэргэжлийн боловсрол олгосон байдал

№	Олгосон мэргэжлийн нэр	Суралцагчдын тоо						Нийт төгсөгчдийн тоо
		2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	
1	Цахилгааны техникч		8	8		3		19
2	Аюулгүй ажиллагааны техникч	8	9	9	7	4	11	48
3	Барилга угсралтын техникч	8	16			2		26
4	Үйлдвэрлэлийн техникч	8			8			16
5	Автомашины засварчин	9	25	5	8	11	20	78
6	Барилгын засал чимэглэлч	13	18	9	9	12	19	80
7	Бетон арматурчин					11	9	20
8	Барилгын өрөг угсрагч	4	21					25
9	Барилгын мужаан		12		3	8	6	29
10	Барилгын сантехникч	12		3			14	29
11	Гагнуурчин	8	18	5	33	39	41	144
12	Цахилгаанчин	17	17	6	14	24	20	98
13	Тогооч	18	21	5	13	10	11	78
14	Хүнд машин механизмын засварчин	30	29		26	24	21	130
15	Оёмол бүтээгдэхүүний оёдолчин	6	24	6	3	7	15	61
16	Цахим тоног төхөөрөмжийн үйлчилгээний ажилтан	24	13		9	5		51
17	Хүнд машин механизмын оператор		75	34	12	14	28	163
18	Хэвлэлийн график дизайн						16	16
19	Өрмийн машины оператор						14	14
20	Үйлдвэрлэлийн машин тоног төхөөрөмжийн механик		18	8		7	22	55
21	Үсчин	10	22		10	13	12	67
Дүн		175	346	98	155	194	279	1247

Эх сурвалж: Өмнөговь аймгийн Политехникийн коллеж

7.6 Дээрх хүснэгтээс харахад хүнд машин механизмын оператор, хүнд машин механизмын засварчин, гагнуурчин, цахилгаанчин, тогооч, автомашины засварчин, барилгын засал чимэглэлч гэсэн мэргэжлээр түлхүү суралцсан байгаа нь орон нутаг дахь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжил олгосон байна.

7.7 Техникийн боловсрол олгох 1.5, 3 жилийн хугацаатай дипломын сургалтад 93, мэргэжлийн боловсрол олгох 2.5 жилийн хугацаатай мэргэжлийн боловсролын үнэмлэх олгох сургалтад 855, мэргэжлийн үнэмлэх олгох 1 жилийн сургалтад 299 иргэнийг тус тус сургаж ур чадварыг нь дээшлүүлсэн байна.

7.8 Хөдөлмөрийн насны нийт төгсөгчдийн ажил эрхлэлт 80.3 хувьтай байгаа нь мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын сургалт, үйл ажиллагаа үр дүнтэй байна.

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

8. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн хөнгөлөлт, чөлөөлөлт нь аж ахуй нэгж, иргэдэд дэмжлэг болсон байна

8.1 Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5⁸, Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолын гурав⁹ дэх заалтад хамрагдсан аж ахуй нэгжийн хөнгөлөлт, чөлөөлөлт дараах байдалтай байна.

Хүснэгт №-13 Нийгмийн даатгалын хөнгөлөлт, чөлөөлөлтийн байдал

/сая төгрөг/

Он	Хамрагдсан ААН-ийн тоо	Чөлөөлөгдсөн дүн
2020	726	24,407.5
2021	796	6,167.2
Нийт дүн	1522	30,574.7

Эх сурвалж: Өмнөговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс

8.2 Судалгаагаар цар тахлын үед ажлын байрыг хадгалах талаар Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээнд зорилтот аж ахуйн нэгжийн 82.0 хувь нь хамрагдсан байна.

8.3 Халдвар цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, хамгаалах ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолын хоёр¹⁰ дахь заалтад хамрагдсан даатгуулагчид олгосон дэмжлэг, чөлөөлөлт дараах байдалтай байна. Үүнд:

- Ажилгүйдлийн даатгалын сангаас 129 аж ахуй нэгж байгууллагын 10856 даатгуулагчид 2,171.2 сая төгрөг,
- Сайн дурын даатгуулагчийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү орлогод ногдох тэтгэвэр, тэтгэмж, үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг тус тус чөлөөлсөн байна.

Хүснэгт №-14 Сайн дурын даатгалын чөлөөлөлтөд хамрагдсан байдал

/сая төгрөг/

Он	Сайн дурын даатгуулагчийн тоо	Мөнгөн дүн
2020	3564	1,337.0
2021	3587	354.2
Нийт дүн	7151	1,691.2

8.4 Цар тахлын үед ажилтныг дэмжих арга хэмжээнд хөдөлмөрийн насны хүн амын 37.5 хувь нь хамрагдсан байна.

⁸ 7.1.5.цар тахлын үед хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн улмаас үйл ажиллагаа нь доголдсон аж ахуйн нэгж, байгууллага, цалин, орлого нь тасалдсан иргэдэд зохих дэмжлэг үзүүлэх;

⁹ 1/ коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын улмаас үйл ажиллагаа нь доголдож, орлого нь буурч байгаа боловч ажлын байрыг хадгалж, хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан ирүүлсэн дараах хуулийн этгээдэд ажиллаж байгаа даатгуулагчаас бусад даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод ногдуулсан ажил олгогч болон даатгуулагч /Монгол Улсын иргэн/-ийн 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд төлөх тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдэл болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг чөлөөлөх ба даатгуулагчийг мөн хугацаанд шимтгэл төлснөөр тооцно

¹⁰ 2.коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын улмаас өөрөөс үл хамаарах шалтгаанаар, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр үйл ажиллагаа нь зогссон болон 2020 оны 2, 3 дугаар сарын үйл ажиллагааны борлуулалтын орлого нь өмнөх оны мөн үеэс 50 ба түүнээс дээш хувиар буурсан боловч ажлын байрыг хадгалж байгаа төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдээс бусад аж ахуйн нэгжийн даатгуулагч Монгол Улсын иргэнд 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд ажилгүйдлийн даатгалын сангаас сар бүр 200.0 /хоёр зуун/ мянган төгрөгийн дэмжлэг олгох;

3/Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан сайн дураар даатгуулсан, нийгмийн даатгалын байгууллагатай мөн хуулийн 5 дугаар зүйлд заасан сайн дураар даатгуулахаар гэрээ байгуулсан Монгол Улсын иргэний 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд түүний хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү орлогод ногдох тэтгэвэр, тэтгэмж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг чөлөөлж, даатгуулагчийг мөн хугацаанд шимтгэл төлснөөр тооцох.

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

8.5 Өмнөговь аймгийн ХХҮГ нь Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 /арван/ их наядын цогц төлөвлөгөө”-ний хавсралтын 2.6¹¹, 2.8¹², 2.10¹³, 2.23¹⁴, 2.24¹⁵- дахь заалтууд болон Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2021 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн 1 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан “Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт №-15 Аж ахуй эрхлэлтийг сэргээх хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээ /сая төгрөг/

Хөтөлбөр, төслийн ангилал	2021				
	Хүн	Төлөвлөгөө	Хүн	Гүйцэтгэл	%
35-аас дээш насны хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр	112	112.7	129	112.7	100
Санхүүгийн дэмжлэг олгох	22	110.0	39	110.0	100
Аж ахуй эрхлэлтийн үр чадвар олгох сургалт	90	2.7	90	2.7	100
Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	55	79.8	55	75.7	94.8
Малчин өрхийг малжуулах	15	75.0	15	74.0	98.7
Аж ахуй эрхлэлтийн сургалт, туршлага солилцох уулзалт зохион байгуулах	40	4.8	40	1.7	35.4
Борлуулалтын дэмжлэг үзүүлэх арга хэмжээ		6.3	2	6.3	100
Ажил олгогчийг дэмжих арга хэмжээ	1	6.0			
Нийтийг хамарсан ажил	150	42.0	177	42.0	100

Эх сурвалж: Өмнөговь аймгийн ХХҮГ

8.6 Цар тахалын үеийн 35-аас дээш насны аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөрт хамрагдахаар 122 иргэн төсөл ирүүлсэн байна. Энэ нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ өндөр байгааг харуулж байна.

8.7 Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 /арван/ их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд бичил бизнес эрхлэгч 12 иргэнд 110.0 сая төгрөг хөнгөлөлттэй зээлийг олгосон байна.

8.8 Дээрх хөнгөлөлттэй зээлийг худалдааны 3, үйлчилгээний 4, үйлдвэрлэлийн 5 аж ахуй нэгжид олгож үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байна.

8.9 Дэмжлэгт хамрагдсан бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн 75 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

8.10 Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхтэй холбоотой ажлын байрны түрээсийн дэмжлэгт 6 хүнд 7.1 сая төгрөг олгосон байна.

¹¹ Залуучуудын хөгжил, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, хувь хүний хөгжлийн цогц сургалтын хөтөлбөр боловсруулан, залуучуудыг хамруулж хөдөлмөрт бэлтгэх, ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлэх

¹² Малжуулах хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй малгүй болон цөөн малтай иргэн, гэрээт малчин өрхийг малжуулахад санхүүгийн зохих дэмжлэг үзүүлэх

¹³ Хувиараа хөдөлмөр эрхлэгч, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг олгох

¹⁴ Хувиараа хөдөлмөр эрхлэх сонирхолтой ажилгүй, гэртээ хүүхэд асарч буй иргэн, хөдөлмөрийн насны халамж хүртэгчид өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхтэй холбоотой борлуулалтын болон ажлын байрны түрээсийн дэмжлэг үзүүлэх

¹⁵ Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрт бэлтгэж ажлын байраар хангах, аж ахуй эрхлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх болон ажлын байраар хангасан аж ахуй нэгж, байгууллагыг дэмжиж, урамшуулах

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

8.11 Цар тахлын үеийн сөрөг нөлөөллийг бууруулах, ажлын байрыг хадгалахад төсвөөс хуваарилсан хөрөнгийг бүрэн зарцуулж ажилласан байна.

8.12 Хөдөлмөр эрхлэлтийн салбарын өөрчлөлт, статистик тоог мэдээг хөдөлмөр эрхлэлтийн анхан шатны нэгж бүр LMIS программаар хөтлөн явуулж байна.

8.13 ХХҮГ-ын доорх мэдээллүүд нь аймгийн Статистикийн хэлтсийн мэдээллүүдтэй тохирч байна.

Хүснэгт №-16 Цар тахлын үеийн хөдөлмөрийн зах зээлийн статистик

№	Үзүүлэлт	2020	2021
1	15 ба түүнээс дээш насны хүн амын тоо	48010	48650
2	Ажиллах хүч	30175	28119
3	Ажиллах хүчний гадуурх хүн ам	11813	17893
4	Ажиллагсдын тоо	28473	26434
5	Ажилгүй иргэдийн тоо	4823	4568
6	Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо	652	703
7	Ажлын шинэ байр	1385	1103
8	Ажилгүйдлийн түвшин	5.6	6.0
9	Хөдөлмөр эрхлэлт (хувиар)	67.8	57.5

Эх сурвалж: Өмнөговь аймгийн ХХҮГ

8.14 Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 2021 онд 51 хувиар өсөж, шинэ ажлын байрны тоо 282-оор буурсан, ажилгүйдлийн түвшин 0.4 хувиар өсөж, хөдөлмөр эрхлэлт 10.3 хувиар буурсан байна.

8.15 Энэ нь цар тахлын нөхцөл байдал үүссэнтэй холбоотой байна.

ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- Төрөөс хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлтэй уялдаж байна
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг тооцоо судалгаанд үндэслээгүй байна
- Төрийн байгууллагуудын чиг үүрэг харилцан уялдаатай байгаа боловч хяналт, шинжилгээ үнэлгээ үр дүнгүй байна
- Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажилд зуучлах арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан байна
- Нэгдсэн бүртгэл, мэдээллийн системийг бүрэн ашиглаж байна
- Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд зарцуулсан хөрөнгийн үр ашгийг бодитой тооцож, тайлагнасан байна
- Дэлхийн банкны санхүүжилтээр “Бичил бизнесийг дэмжих” хөтөлбөрийг хэрэгжүүлж ажилласан байна
- Хөтөлбөрүүдийн хэрэгжилт, зээлийн эргэн төлөлтөд тавих хяналт хангалтгүй байгаа нь хөтөлбөрийн үр дүнг бууруулж байна
- Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар зохион байгуулсан арга хэмжээ байхгүй байна
- Орон нутгийн төсвөөс хуваарилах хөрөнгийг дэд санд төвлөрүүлээгүй байна
- Сангийн хөрөнгийг хууль журмын дагуу орон нутгийн онцлогт тохируулан зарцуулсан ч хөтөлбөрүүдийн үр дүнг тооцоогүй байна
- Мэргэжлийн боловсрол олгох сургалтын байгууллагаас хөдөлмөрт бэлтгэх үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлсэн байна
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн хөнгөлөлт, чөлөөлөлт нь аж ахуй нэгж, иргэдэд дэмжлэг болсон байна

ЗӨВЛӨМЖ

Аймгийн Засаг даргад:

- Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд орон нутгийн төсвөөс жил бүр олгох хөрөнгийн хэмжээ нь тухайн төсвийн орлогын 0.3 хувиас доошгүй байна гэж заасныг хэрэгжүүлэн орон нутгийн төсвөөс хөдөлмөр эрхлэлтийн дэд санд хуваарилах хөрөнгийг орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх

Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлд:

- Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр батлагдсан хөтөлбөрүүд болон орон нутгийн онцлогтой хөтөлбөр төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтийг нь удирдан зохицуулах, биелэлтэд нь хяналт тавих, жил бүр үнэлгээ хийж, санал дүгнэлт гаргаж байх

Аймгийн хөдөлмөр, халамж, үйлчилгээний газрын даргад:

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулаагүйн төлбөрийн орлогын эх үүсвэрийг бодитой тодорхойлж, сангийн орлогыг нэмэгдүүлэх, аж ахуй нэгж, байгууллагад Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.3 дахь заалтын хэрэгжилтийг хангуулж ажиллах

- Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааг дэмжиж төсөл хөтөлбөрийн санхүүжилт олгохдоо жижиглэхгүй байх, төсөл сонгон шалгаруулалт хийхээсээ өмнө төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаатай танилцаж бодитой хэрэгжих болохуйц төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны үр дүнд хөндлөнгийн байгууллагаар жил бүр хяналт, шинжилгээ, үнэлгээ хийлгэж байх

- Хяналт шинжилгээ үнэлгээний чанарыг сайжруулан, зөвлөмж хангалтгүй биелүүлсэн албан тушаалтанд хариуцлага тооцох саналыг эрх бүхий албан тушаалтанд гаргаж, үр дүнг тооцож ажиллах

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР

3 дугаар баг, Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083

Утас: (976) 70533910,

Цахим шуудан: info@omnogovi.hudulmur-halamj.gov.mn,

Цахим хуудас: www.omnogovi.hudulmur-halamj.gov.mn

2022. 05. 04 № 193
танай _____-ны № _____-т

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүнд хийсэн 2016-2021 оны гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж, дүгнэлт, арга зүйн талаарх саналгүй бөгөөд зөвлөмжийн дагуу төлөвлөгөө боловсруулан үр дүнг тооцон ажиллах болно.

ДАРГА

Б.ДОЛЖИНСҮРЭН



1122030017

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2022 оны 5 сарын 4 өдөр

Дугаар А/М

Даланзадгад

“Аудитын тайлан баталгаажуулах тухай”

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 8 дугаар зүйлийн 8.1, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Аудитын гуравдугаар газар, Аймгийн Засаг дарга, Өмнөговь аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт тус тус хүргүүлсүгэй.
3. Аудиттай холбоотой ажлын нотлох баримтыг тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөх, аудитын тайланг хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэхийг ахлах аудитор (Д.Сүрэнжаргал)-д үүрэг болгосугай.

С.ЦЭРЭНБАЯР

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

ХАВСРАЛТ № 1

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө 2016-2021 он															
														/сая төгрөгөөр/	
№	Төсөл, хөтөлбөрийн нэр	2016 он		2017 он		2018 он		2019 он		2020 он		2021 он		Нийт дүн	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	57.4	57.4	52.3	27.1	52.3	75.3	84.5	183.5	167.0	0.8	0.8	18.0	414.3	362.1
2	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	61.9	61.9	105.2	38.6	105.2	62.8	98.0	66.4	66.3	65.2	65.2	90.0	501.8	384.9
3	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	275.5	275.5	301.0	197.2	301.0	236.2	210.0	240.0	215.0	0.0	0.0	79.8	1,302.5	1,028.7
4	Нийтийг хамарсан ажил	92.2	92.2	70.0	145.9	70.0	64.4	75.0	64.9	64.9	20.0	20.0	42.0	392.1	429.4
5	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	293.7	293.7	361.6	159.5	221.6	273.2	247.5	305.9	305.9	255.1	255.1	125.3	1,685.4	1,412.7
7	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	0	0	140.0	140.0	14.0	16.2	14.0	14.4	14.4	10.9	10.9	10.9	193.3	192.4
8	Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр	75.6	75.6	40.1	33.5	40.1	25.1	42.4	25.1	25.1	0.0	0.0	2.2	223.3	161.5
9	Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр	0	0.0	0.0	0.0	0.0	0.0			0.0	0.0	0.0	110.0	0.0	110.0
10	Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	15	15.0	50.0	7.5	50.0	12.0	50.0	24.0	24.0	24.0	24.0	27.0	213.0	109.5
11	Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх "Оролцоо" төсөл	0	0	0	0	0	0			0.0	0.0		0.0	0.0	0.0
12	Ажилд зуучлах үйлчилгээ	4.0	4.0	8.4	10.3	8.4	9.2	3.6	9.6	9.6	0.0	0.0	2.2	34.0	35.3
13	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ	11.6	11.6	7.9	7.8	7.9	9.9	19.6	12.0	12.0	6.1	6.1	5.1	65.1	52.5
14	Хүүхэд хамгаалагч үйлчилгээ	0	0	0.0	0.0	0.0	0.0	0.0	4.7	4.7	4.7	4.7	2.3	9.4	11.7
15	Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлөөс дэмжсэн орон нутгийн онцлогтой төсөл	0	0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
15	ЗГ-ын шийдвэрийн дагуу аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлөөс баталсан бусад хөтөлбөр, төсөлийн санхүүжилт	0	0	0	0	0	100.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	100.0
16	Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээ	0	0	0.0	0.0	0.0	0.0	0.0	10.0	0.0	193.0	0.0	110.0	0.0	313.0
ДҮН		886.9	886.9	1136.5	767.4	870.5	884.3	844.6	960.5	908.9	579.8	386.8	624.8	5034.2	4,703.7

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”

ХАВСРАЛТ № 2

ХЭДС-аас 2016-2021 онд хэрэгжсэн төсөл хөтөлбөрүүдэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээ

Д/д	Төсөл, хөтөлбөрийн нэр	Зөрчлийн мэдээлэл					Гарсан зөрчлийн товч утга
		Хамрагдсан төсөл /тоо/	Гарсан зөрчил /тоо/	Мөнгөн дүн /сая төгрөг/	Өгсөн зөвлөмж /тоо/	Мэдэгдэх хуудас /тоо/	
1	Ажилтай орлоготой эмэгтэйчүүд	10	1	2.0	1	.	Төслийг хэрэгжүүлэгч ажилд орсон.
2	Хувиараа хөдөлмөр эрхлэгч нөхөрлөл хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр	35	1	1.0	1	.	Төсөл хэрэгжүүлэгч ажилд орсон.
3	Говийн оюу сан "Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"	80	13	-	13	0	Гэрээгээр заасан үүргийн 3.3 дахь заалт Нийгмийн даатгалын шимтгэл төлөх заалтыг зөрчсөн. /13 төсөл/ Зарим төслүүдийн тайлан мэдээ шаардлага хангахгүй байна. Гэрээний дагуу ажлын байр нэмэгдүүлээгүй.
4	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	35	0	-	0	0	Зөрчилгүй.
5	Хөдөлмөрт бэлтгэх хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр	5	0	-	0	0	Зөрчилгүй.
6	Говийн оюу сан "Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"	90	13	-	13	0	Гэрээгээр заасан үүргийн 3.3 дахь заалтыг зөрчсөн. Зарим төслүүдийн тайлан мэдээ шаардлага хангахгүй байна. Гэрээний дагуу ажлын байр нэмэгдүүлээгүй.
7	З-н сумын төсөл хөтөлбөрийн хяналт	6	6	-	6	0	Зөрчилгүй.
8	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр /2016/	16	16	25.8	16	0	Эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн
9	ХЭДС-аас төсөл авсан иргэдийн хяналт	11	0	-	0	0	Зөрчилгүй.
10	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг хөтөлбөр /2021/	36	36	-	36	0	Эргэн төлөлтөө хуваарийн дагуу хийж эхлээгүй.
11	ХЭДС-ийн төслүүдийн хяналт	22	36	-	36	0	Эргэн төлөлтөө хуваарийн дагуу хийж эхлээгүй.
12	Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хяналт /2018-2020/	50	15	-	0	15	Эргэн төлөлтөө хийгээгүй хугацаа хэтэрсэн.
13	Нийтийг хамарсан ажлын төслийн хяналт	3	0	-	0	0	Зөрчилгүй
Нийт		399	137	28.8	122	15	

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”